



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 483

Улаанбаатар хот

Хариуцлага тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 19 дүгээр зүйл, үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контрактын 3 дугаар зүйлийн 3.2.12, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 13 дугаар зүйлийн 13.8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Буянт-Ухаа спортын ордон” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Л.Энхбаяр нь зургаа хүртэлх сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй тул түүний албан тушаалын цалингийн хэмжээг гурван сарын хугацаатай 30 хувиар бууруулсугай.

2.Захирал Л.Энхбаярын албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 30 хувиар бууруулан тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (А.Халиун)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001424

\Huraldaanii material\2021 on\2021.11.11-р huraldaan.docx